



# МОНГОЛ ОРНЫ ЖИГҮҮРТЭН

## фото зургийн уралдаан



Монголын зэрлэг амьтан судлах хамгаалах төв болон Монголын шувуу ажиглагчдын клуб хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулж байгаа Монгол орны жигүүртэн амьтад болон тэдгээрийн амьдрах орчны тухай фото зургийн уралдаанаа зарлаж байна.

Энэхүү уралдаан 2010 оноос эхлэн зохион байгуулагдаж байгаа бөгөөд манай анхны уралдаанд 8 орны (Монгол, Орос, Герман, АНУ, Англи, Франц, Өмнөд Солонгос, Унгар) 26 оролцогсад нийт 65 зүйлийн 90 фото зураг ирүүлсэн. 2010 оны уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг энд дарж сонирхоно уу [http://www.wssc.org.mn/photo\\_contest/index.html](http://www.wssc.org.mn/photo_contest/index.html).

Монгол орны жигүүртэн амьтад фото зургийн уралдаан нь Монголын ард иргэдийг байгаль хамгаалах, түүний дотроос жигүүртэн амьтадыг хамгаалах үйлсэд татан оролцуулах, иргэдийн дунд шувуу ажиглах сонирхолыг хөхүүлэн дэмжих зорилгоор зохион байгуулагдаж байгаа болно.

Уралдаанд оролцохыг хүсэгчид фото зураг, материалаа 2011 оны 12 дугаар сарын 15-ны дотор [info@wssc.org.mn](mailto:info@wssc.org.mn) хаягаар ирүүлнэ үү. Уралдаанд ирүүлэх бүтээл нь байгаль дээр авсан зэрлэг шувууны болон тэдний амьдрах орчны тухай байх ёстой. Хашаанд, зуслангийн эдлэнд авсан зураг байж бас болно. Харин шувууны өндөг, ангаахайн зургийг хүлээн авахгүй. Зурган дээр хүн, мал шувуудын хамт гарсан байж болно. Нэг оролцогч авсан зурагнуудаасаа шилж сонгосон 1-3 бүтээлээ явуулах ёстой. Зургийн файлын хэмжээ 10МВ-аас хэтрэх байна. Мөн хамгийн өндөр нягтшилаараа байвал сайн. Нягтшил муутай зургийг оролцуулах боломжгүй.

Уралдаанд ирүүлж багаа бүтээл нь нэр, зураг авсан он сар өдөр, газрын нэртэй байхаас гадна, зурагчин өөрийн овог нэр, нас, мэргэжил, холбоо барих и-майл хаяг, утасны дугаараа ирүүлсэн байх ёстой. Уралдаанд шалгарсан оролцогсодтой и-майлээр холбоо барих бөгөөд ЗАСХТ, МШАК-ын вебсайтан дээр зарлан тавих болно.

Уралдаанд ирүүлсэн бүтээлээс нэг зургийг шилдэгээр шалгаруулж тэргүүн байрны шагнал, гэрчилгээ олгох болно. Мөн удаах байранд орсон хоёр бүтээлийг шалгаруулж тусгай шагнал гардуулана. Мөн шалгарсан бүтээлийг нийтийн хүртээл болгон зарлах болно.

Уралдаанд ирсэн фото зургуудын зохиогчын эрх бүтээлээ ирүүлсэн зурагчинд хадгалагдах болно. Гэхдээ энэхүү уралдаанд зургаа ирүүлсэнээр оролцогсод өөрсдийн бүтээлээ ЗАСХТ болон МШАК-т үнэгүй, ашгийн бус зорилгоор ашиглах, мөн өөрийн нэр, бүтээлийг уг уралдаантай холбоотой аливаа төрлийн сурталчилгаанд ашиглах эрх олгож байгаагаа хүлээн зөвшөөрч байна гэж үзнэ.



2010 оны уралдаанд шалгарсан зурагнуудаас



*Та бүхэнд амжилт хүсье*

*Монголын зэрлэг амьтан судлах хамгаалах төв  
Монголын шувуу ажиглагчдын клуб*